



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нутгаар явж Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн нягтралыг сайжруулах ажилд хэрэглэгдэх, орон сууцны хороолол дотор байгуулах "Ойн төгөл"-д таригдах мод, сөөгний нөөцийг тодорхойлох, шилмүүст нарс модны ургалтыг сайжруулах дуслын шингэн, биобордооны үйлдвэрлэлтэй танилцаж, бүтээгдэхүүнийг судлах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Мод, сөөг, дуслын шингэн, биобордооны нөөцийн судалгаа хийх ажлын удирдамжийг 2 дугаар, ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Мод, сөөг, дуслын шингэн, биобордооны нөөцийг судлах ажилд шаардагдах нийт 287.200 /Хоёр зуун наян долоон мянга хоёр зуун/ төгрөгийг Хот тохижилтын төсөвлөгдсөн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/ -д зөвшөөрсүгэй.

4. Мод, сөөг, дуслын шингэн, биобордооны нөөцийг судалсан ажлын дүнг 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотын Ерөнхий менежер танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Сүхбат/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 03-р сарын 17-ний өдрийн
А/61 тушаалын 4 дүгээр хавсралт



МОД, СӨӨГ, ДУСЛЫН ШИНГЭН, БИОБОРДООНЫ
НӨӨЦИЙГ СУДЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ногоон байгууламжийн мэргэжилтэн
	Б.Чимид	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны гэрээт ажилтан, Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан, доктор

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн
№61 тушаалын Дугаар хавсралт

МОД, СӨӨГ, ДУСЛЫН ШИНГЭН,
БИОБОРДООНЫ НӨӨЦИЙН СУДАЛГАА ХИЙХ
АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

2019 онд хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт болон орон сууцны хороолол дотор байгуулах "Ойн төгөл"- д тарих мод, сөөгний нөөц болон шилмүүст модны дуслын шингэн, биобордооны үйлдвэртэй танилцаж нөөцийг судлах ажлын хэсэг 2019 оны 03 дугаар сарын 15-17,-ны өдрүүдэд Сэлэнгэ, Дархан-уул аймгийн мод үржүүлгийн газрууд болон биобордоо, шилмүүст модны дуслын шингэний үйлдвэрүүдтэй танилцан, дараах суулгац, бордоо, дуслын шингэний нөөцийг судлана.


Хоёр. Нөөцийг судлах ажлын чиглэл

- Үүнд:
- а/. Наадамчдын замын урд талаар тарих 3-4 настай, 80-120 см өндөртэй, 5000 ширхэг буюу 1100 бут голт бор сөөг
 - б/. Наадамчдын замын урд талаар тарих 3-4 настай 100-150см өндөртэй хайлаасны 110000 ширхэг суулгац
 - в/. Багатойруугийн гудамжинд тарих гоёлын 4-5 настай тэхийн шээг, боролзгоно гэх мэтийн бут сөөг
 - г/. 22-ын товчооны зам дагууд тарих 4-5 настай , 3.0-4.0 метрийн өндөртэй, 3-5 настай 5000 ширхэг улиасны суулгац
 - д/. Орон сууцны дотор байгуулах "Ойн төгөл"-д тарих 3-5 настай улиас, хус, шинэс, монос, өрөл, долоогоно, хайлаас гэх мэт мод сөөгний суулгац
 - е/. Оршуулгын газарт тарих 2-3 настай, 50-80см өндөртэй хайлаасны суулгац
 - ё/. Дархан хотын "Био агро" ХХК , "Био ундарга" ХХК -ын шилмүүст модны дуслын шингэн, азотын бордоо, "Дархан ризо" био бордооны үйлдвэр, түүний бүтээгдэхүүнтэй танилцана.

Гурав. Үр дүнг танилцуулах

Мод, сөөг, дуслын шингэн , биобордооны нөөцийг судалсан ажлын дүнг 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны *Огуст* сарын *Ашиг* өдрийн
1/6 тушаалын *бүтээг* хавсралт



МОД, СӨӨГ, ДУСЛЫН ШИНГЭН, БИОБОРДООНЫ
 НӨӨЦИЙГ СУДЛАХ АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр, төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хянасан
1.	Унааны шатахуун- Prius /УБ – Дархан – Шарын гол – Сэлэнгэ - УБ/	920км x8л=74л	1732	128.200	
2.	Томилолт /2хоног/	Дархан хот. 1хоног /ТЗ албан хаагч 2 хүн/ /Гэрээт ажилтан/	35500	71.000	
		Сэлэнгэ аймаг. 1хоног /ТЗ албан хаагч 2 хүн/ /Гэрээт ажилтан/	29.000	58.000	
			14.000	14.000	
	ДҮН /төгрөг/			287.200	